



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/490

Арвайхээр

Хайрхандулаан сумын Засаг даргын Тамгын 7  
газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хайрхандулаан сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоож, бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

2. Хуульд заасан эрх хэмжээний дагуу сумын Засаг даргын Тамгын газрын ажилтнуудын ажлын байрны чиг үүргийг тодорхойлон, хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга /Ч.Ганхуяг/, Засаг даргын Тамгын газрын дарга /А.Батсайхан/ нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ц.Ганболд/-т үүрэг болгосугай.

3. Шинээр батлагдсан бүтэц, орон тоог 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг сумын Засаг дарга /Ч.Ганхуяг/-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан “Сумдын Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай” 2015 оны а/488, “Захирамжид өөрчлөлт оруулах тухай” 2016 оны а/50, “Захирамжид өөрчлөлт оруулах тухай” 2017 оны а/538 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Т.ГАНБОЛД

011101050

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2018 оны 07  
 дугаар сарын 30-ны өдрийн 11490 дүгээр  
 захирамжийн хавсралт

UICAA0003 9044051

ХАЙРХАНДУЛААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

Сумдын нэр	Албан тушаалын нэр	Орон тоо
Хайрхандулаан	Засаг дарга	1
	Засаг даргын орлогч	1
	Тамгын газрын дарга	1
	Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч	1
	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	1
	Төрийн захиргааны түшмэл	1
	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	1
	Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн	1
	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэн	1
	Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	1
	Бэлчээрийн менежмент, газар тариалан, хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	1
	Хөдөлмөрийн нийгмийн ажилтан	1
	Нягтлан бодогч	3
	Багийн Засаг дарга	6
	Архив, бичиг хэргийн эрхлэгч	1
	Нярав-үйлчлэгч	1
	Жолооч	1
Бүгд		24